



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 6 сарын 15 өдөр

Дугаар 29

Мандалговь


Г

Д.Төмөртогтохыг албан тушаалд нэр
дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2020 оны 5 дугаар хуралдааны шийдвэр, төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын комиссын 2020 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Өлзийт сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Довчиншаравын Төмөртогтох 67.8 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр. Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Д.Төмөртогтохын санал, дүгнэлтийг хавсралтаар баталж, холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.



732821063

Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2020 оны 15.. дугаар сарын
15.. -ны өдрийн 10.. дүгээр тогтоолын хавсралт



**Өлзийт сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан
мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлсэн Довчиншаравын
Төмөртогтохын тухай дүгнэлт**

1. Д.Төмөртогтох нь 1977 онд Дундговь аймгийн Мандалговь хотод төрсөн. 43 настай. Эрэгтэй.
2. Боловсролын байдал: Их засаг их сургуулийг 1997-2001 онд Эрх зүйч мэргэжлээр, бакалавр зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Ажлын туршлага: 2001-2004 онд аймгийн ЗДТГ-т хуулийн зөвлөх, 2004-2008 онд Гурвансайхан сумын ЗДТГ-ын дарга, 2010-2013 онд Өлзийт сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, 2013-2016 онд Гурвансайхан сумын Засаг дарга, 2016-2017 онд аймгийн ЗДТГ-т мэргэжилтэн, 2020 оноос Өлзийт сумын ЗДТГ-т хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байгаа.
4. Д.Төмөртогтохын төрийн захиргааны албанад ажиллаж байгаа ажлын дадлага туршлага, тухайн ажлын байрны өрөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Өлзийт сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛ